



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/106

Мандалговь

┌ “СДММ” ХХК-тай гэрээ байгуулах тухай ┐

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сургуулийн барилгын их засвар (Дундговь, Өлзийт сум)”-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “СДММ” ХХК-тай 377,484,314 (гурван зуун далан долоон сая дөрвөн зуун наян дөрвөн мянга гурван зуун арван дөрөв) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Сургуулийн барилгын их засвар (Дундговь, Өлзийт сум)” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “СДММ” ХХК-ийн захирал (Д.Оргилдалай)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Өлзийт сумын Засаг дарга (А.Эрдэнэбат), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060452